



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



ХҮҮХДИЙГ ЗОХИСГҮЙ
АГУУЛГААС ХАМГААЛАХ
ЗӨВЛӨЛ

Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн
дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих орон тооны бус зөвлөлийн
2025 оны 4-р улирлын ээлжит хуралдаан боллоо

2025.11.18

Харилцаа холбооны зохицуулах хорооны дэргэдэх Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих Орон тооны бус зөвлөлийн 2025 оны дөрөвдүгээр улирлын ээлжит хурал 11 дүгээр сарын 18-ны өдөр боллоо.

Тус зөвлөл нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.7 (а) дахь хэсэгт заасан Зохицуулах хорооны чиг үүргийн хүрээнд улирал тутам хуралдаж, хүүхдэд зохисгүй агуулга бүхий кино, нэвтрүүлэг нэвтрүүлсэн талаарх гомдол, мөн 18+ насны ангилалтай кино, бүтээлийг цагийн хязгаарлалт зөрчиж нэвтрүүлсэн хяналт-мониторингийн дүнг хэлэлцдэг.

Радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм зөрчсөн зохисгүй агуулга бүхий кино, нэвтрүүлэг гарсан талаарх гомдол ирсэн болон 18+ насны ангилалтай киног цагийн хязгаарлалт зөрчиж, зохисгүй агуулга нэвтрүүлсэн телевизүүдэд Зөвлөлийн дүгнэлтийн дагуу зөвлөмж, мэдэгдэл хүргүүлж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлж байна.

2025 оны 4-р улиралд Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах Радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм зөрчсөн зохисгүй агуулгатай холбоотой 1 гомдол ирсэн.

Зөвлөлийн хуралдаанаар радио, телевизийн хөтөлбөрт хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах чиг үүргийнхээ хүрээнд дараах асуудлыг хэлэлцлээ.

1. Телевизүүдийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн 2025 оны 9,10 дугаар сарын дүнгээс 18+ тэмдэглэгээтэй кино, нэвтрүүлгийг цагийн хязгаарлалт зөрчсөн, өдрийн цагаар болон 22:00 цагаас өмнө Радио, телевизийн хөтөлбөрийн дүрмээр хязгаарласан илт зохисгүй гэж үзэж болох агуулга нэвтрүүлсэн нь бүртгэгдсэнтэй холбоотой тайлан
2. Орон тооны бус зөвлөлийн 2025 оны 3-р улирлын хурлаас гарсан дүгнэлтийн дагуу хүргүүлсэн телевизүүдэд хүргүүлсэн зөвлөмж, мэдэгдлийн хэрэгжилтийн явц.

- Нэр бүхий телевизүүд 18+ тэмдэглэгээтэй кино, нэвтрүүлгийн цагийн хязгаарлалтын зөрчлийг арилгасан эсэх
 - Цагийн хязгаарлалт зөрчсөн тайланд Радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм зөрчиж илт зохисгүй агуулга нэвтрүүлсэн эсэх, эдгээр зөрчил давтагдсан эсэх
3. Нэр бүхий иргэнээс ирсэн фм радиогоор нэвтрүүлсэн зохисгүй агуулгын талаарх гомдлыг тус тус хэлэлцлээ.

Мониторингийн үр дүнд илэрсэн нийтлэг зөрчлүүд

1. Өдрийн болон оройн цагт 18+ ангилалтай контент нэвтрүүлэх

- 06:00–22:00 цагийн хооронд 18+ тэмдэглэгээтэй кино, нэвтрүүлэг нэвтрүүлсэн таван телевиз (Хөгжил ТВ, Мянгат малчин, NTN, Channel 11, 25-р суваг) бүртгэгдэв.
- Ихэнх тохиолдолд насны ангиллыг буруу тогтоож тавьсан
- 22 цагаас хойш нэвтрүүлсэн 18+ тэмдэглэгээтэй контентыг маргааш нь өдөр, оройн цагаар давтан нэвтрүүлсэн зөрчил түгээмэл илэрсэн.
- Стандартад нийцээгүй насны ангиллын тэмдэглэгээ ашигласан зөрчил
 - Кино нэвтрүүлэхдээ насны ангиллын тэмдэглэгээг MNS 6587:2020 стандартын дагуу тавиагүй, эсхүл тэмдэглэгээ огт тавиагүй - 4ТВ бүртгэгдсэнээс Лайк, Сүлд, Өндөрхаан, D1 телевизүүд нь 22:00 цагаас өмнө, өдрийн цагаар Радио, телевизийн хөтөлбөрийн дүрмээр хязгаарласан илт зохисгүй гэж үзэж болох агуулгатай зохисгүй агуулгатай контент нэвтрүүлсэн нь бүртгэгдсэн.
 - Зарим гаднын бүтээлд MNS 6587:2020 стандартад заасан 12+, 18+ ангиллын оронд 15+, 21+ гэх мэт стандартад заагаагүй ангилал ашигласан зөрчил түгээмэл байна.

Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм зөрчиж зохисгүй агуулга нэвтрүүлсэн эсэхэд дүгнэлт гаргах чиглэлээр дараах асуудлыг хэлэлцлээ

1. 18+ тэмдэглэгээтэй болон насны ангиллын тэмдэглэгээ огт тавиагүй өдрийн цагаар, 22:00 өмнө Радио, телевизийн хөтөлбөрийн дүрмээр хязгаарласан илт зохисгүй гэж үзэж болох агуулгатай контент нэвтрүүлсэн телевизүүд;
2. Нэр бүхий иргэнээс ирүүлсэн хууль тогтоомж зөрчиж, ФМ радиогоор зохисгүй агуулга нэвтрүүлсэнтэй холбоотой ирүүлсэн гомдлын талаар тус тус хэлэлцэж дүгнэлт гаргалаа.

Зөвлөлийн хуралдаанаар дараах нэр бүхий 4 телевизээр өдрийн цагаар нэвтрүүлсэн зохисгүй агуулгыг хэлэлцээд Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрмээр хязгаарласан дараах агуулгыг нэвтрүүлсэн гэж дүгнэлээ. Үүнд:

- Хүүхэд залуусын сэтгэхүйд сөргөөр нөлөөлөх агуулга
- Садар самуун, бэлгийн амьдралыг дэлгэрэнгүй харуулсан,
- Гэмт хэргийн үйлдлийг нарийвчлан зааварчилсан, цус эд эрхтнийг авахыг харуулах, хүүхдийг айдас цочролд автуулах агуулгатай буюу зохисгүй агуулга нэвтрүүлсэн

Иймд дээрх телевизүүдийг Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрмийн 2.3.2, 2.3.5, 2.5.4, 2.7.2 дахь хэсгийн шаардлагыг зөрчсөн гэж үзэж байна.

Зөвлөлөөр хэлэлцээд авсан арга хэмжээ

- Радио, телевизийн хөтөлбөрийн дүрмээр хязгаарласан зохисгүй агуулга бүхий киног өдрийн цагаар насны ангиллын тэмдэг, тэмдэглэгээг байршуулаагүй контентыг нэвтрүүлсэн, зохисгүй агуулгыг хаах, хязгаарлах арга хэмжээ аваагүй Лайк, Сүлд, Өндөрхаан, D1 телевизүүд нь өмнө нь зөрчил гаргаж байгаагүйг харгалзан, зөрчлийн талаар мэдэгдэл анхааруулга хүргүүлэх. Зөрчил дахин давтагдвал Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль зөрчсөнд тооцогдох үндэслэл болох тул Зөрчлийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхээр **Зөрчил шалган шийдвэрлэх харьяаллын дагуу шилжүүлэх** талаар мэдэгдэлд тусгаж анхааруулах нь зүйтэй гэж дүгнэв.
- Өдрийн болон оройн цагт буюу 06:00-22:00 цагийн хооронд 18+ насны ангилалтай кино нэвтрүүлж, цагийн хязгаарлалтыг зөрчсөн хэдий ч зохисгүй агуулга нэвтрүүлээгүй Мянгат малчин, NTN, Channel 11 телевизүүдэд Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газраас хөтөлбөрийн хяналт, мониторингийн хүрээнд анхааруулга, мэдэгдлийг хүргүүлэхээр болов.
- Харин зөрчлөө удаа дараа давтан гаргасан бөгөөд өмнө нь Зөвлөлөөс зөвлөмж, мэдэгдэл хүргүүлж байсан 25-р суваг, Хөгжил телевизийн насны ангиллын цагийн хязгаарлалт зөрчсөн зөрчлийн асуудлыг зөвлөлөөр хэлэлцлээ. Тухайн 2 телевизийн 22:00 цагаас өмнө нэвтрүүлсэн 18 + ангиллын кино, нэвтрүүлэгт Хүүхдийн хөтөлбөрийн дүрмээр хязгаарласан зохисгүй агуулга бүртгэгдээгүй, гомдол ирээгүй, мөн уг зөрчил нь анхааруулга мэдэгдэл хүргүүлэхээс өмнөх хугацааг хамарч байгааг харгалзан Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага, Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын хэрэгжилтийн хүрээнд ӨНЗГ-аас дээрх 2 телевизэд мониторингийн дүнгээр өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлт, зөвлөлийн 3-р улирлын хурлаас хүргүүлсэн мэдэгдэл анхааруулгын биелэлтийн хүрээнд шаардлагатай арга хэмжээгээ авч үзэх нь зүйтэй гэж дүгнэлээ.

Харин хугацаатай үүрэг даалгаврын хүрээнд цагийн хязгаарлалтын зөрчлийг давтсан тохиолдолд Хүүхэд хамгааллын тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль зөрчсөнд тооцож, Зөрчлийн тухай хуулийн 6.20.10-т заасны дагуу өөрийн үйлчилгээнд хүүхдэд хортой агуулгыг хянах, хязгаарлах, хаах арга хэмжээ авах

үүргээ биелүүлээгүй үндэслэлээр цаашид Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцуулахаар Зөрчил шалган шийдвэрлэх харьяаллын дагуу шилжүүлэх арга хэмжээг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Мөн УБ хотын нэгэн ФМ радиогоор 18+ насны ангиллын нэвтрүүлгийг 22:00 цагаас хойш нэвтрүүлсэн ч Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, *Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага болон Радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм* зөрчсөн, зохисгүй агуулга бүхий нэвтрүүлгийг цацсан талаарх гомдол тус хороонд ирүүлснийг зөвлөлийн хуралдаанаар хэлэлцлээ.

Гомдолд “.... фм радиогоор цагийн хязгаараар халхавчлан ил тод садар самуун агуулгатай нэвтрүүлэг цацагдсанаар Монгол Улсын хууль тогтоомжийн зорилгыг үл биелүүлж, хүүхдийг төдийгүй иргэдийг эрсдэлд оруулж, хүчирхийлэл үйлдэхийг өдөөх, сэдэлжүүлэх, хохирогч бий болох нөхцөлийг бүрдүүлэх эрсдэлд оруулж байна.....” гэж дурджээ.

Гомдлын дагуу зөрчил гаргасан гэх MGL 88.3 фм радиогийн үйлчилгээ эрхлэгчид гомдлыг албан бичгээр мэдэгдэж, хариу тайлбарыг авч ажиллалаа. Хариу тайлбарт “Ирүүлсэн санал, гомдлыг хүлээн авч, манай байгууллага уг нэвтрүүлгийн эфирийг түр хугацаагаар зогсоох шийдвэр” гаргасан тухай мэдэгдэв. Цаашид тус фм радиод нэвтрүүлгээ бэлтгэн хүргэхдээ цагийн хязгаарлалтыг чанд баримтлан, Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрмийг мөрдөн, зохисгүй **агуулгыг хянах, хязгаарлах арга хэмжээ авч** ажиллахыг зөвлөлөө.

Зөвлөлийн хуралдаанаас дээрх телевиз, радиод зөрчлийг давтан гаргахгүй байхыг анхааруулж, цаашид зөрчил давтагдвал холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн үндэслэлээр:

- Зөрчлийн тухай хуулийн 6.20.10-т заасны дагуу хүүхдэд хортой агуулгыг хянах, хязгаарлах, хаах арга хэмжээ авах үүргээ биелүүлээгүй;
- мөн 9.13 дугаар зүйлийн 2-т заасны дагуу 18 + ангиллын киног цагийн хязгаарлалт зөрчиж нэвтрүүлсэн зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх харьяаллын дагуу холбогдох байгууллагад шилжүүлэх арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй гэсэн санал дүгнэлт гарлаа.

ТАНИЛЦСАН:

Э.ЗОЛБАЯР

ХЯНАСАН

Н.ТОГТОХСҮРЭН

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

Г.ГАНЧИМЭГ

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР